



АЛТАЦӨГЦ СУМЫН ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧИЙН 2017 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

**Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл
дараах хаягаар харилцана уу:**

Баян-Өлгий аймгийн
Аудитын газар

Тэргүүлэх аудитор
М.Хуанган
Утас:70422954
Цахимхаяг:

Хавсралт 1: Агуулга

Хавсралт 2: Аудитын гэрчилгээ

Хавсралт 3: Менежментийн захидал

Хавсралт 4: Аудит хийсэн санхүүгийн тайлан

Хавсралт 5: Төсвийн гүйцэтгэлийн тайлантайлан

Аудитын менежер:
Х.Женисбек
Утас: 70422930
Цахимхаяг:

Аудитор: Б.Үүрийнтуяа
Утас: 89838414
Цахимхаяг:

Хаяг: Баян-Өлгий аймаг дахь
Төрийн аудитын газар

Байршил: Өлгий сум, 5-р баг,
Аймгийн ЗДТГазрын байр, 1-р
давхар
Цахим хуудас:

2018 оны 3 дугаар сар

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйлажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитынарга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорилболон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Дотоод хяналт
6. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
7. Шилэн дансны мэдээлэл
8. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
9. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
10. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:
11. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:
12. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
13. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
14. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
15. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
16. Зөвлөмж
17. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:

Төсвийн тухай хуулийн 8.9.3, Төрийн аудитын тухай хуулийн 15.2.1 дэх заалтыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 18.2 дүгээр зүйлд заасан Аймаг дахь Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Алтанцөгц сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн тайланд / БӨА-2018/7/СТА-ТТЗ/ аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Алтанцөгц сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Алтанцөгц сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайлангийн аудитыг 2018 оны 3 дугаар сарын 12-ноос 2018 оны 3 дугаар сарын 19-ны хооронд хийхээр төлөвлөн, хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

Алтанцөгц сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг 2018 оны 3 дугаар сарын 01-нд УАГ-ын харьяа Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлсэн байна.

Аудитын газар аудитыг 2018 оны 3 дугаар сарын 12-наас 3 дугаар сарын 20-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 03 дугаар сарын 26-нд Алтанцөгц сумын Засаг даргад гардуулав.

Байгууллагын хууль, эрх зүйн орчин:

Алтанцөгц сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь Монгол Улсын Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Татварын багц хуулиудийн хүрээнд үйл ажиллагаа явуулж байна. Тайлант онд тухайн байгууллагын

Алтанцөгц сумын ТТЗ-ийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудит санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хууль, тогтоомж, түүнд нийцүүлэн гарсан журам, зааварт өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын зорилго,үйлажиллагаа:

Монгол Улсын Засаг захиргааны нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 4-р зүйлд “Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага нь нутгийн өөрөө удирдах ёсыг төрийн удирдлагтай хослуулах үндсэн дээр нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн амьдралын асуудлыг бие даан зохион байгуулж, ардчилсан шударга ёс, эрх чөлөө тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангаж ажиллах” гэж энэ байгууллагын үйл ажиллагааны зорилтыг тодорхойлсон байна.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д “Төсвийн ерөнхийлөн захирагч нь өөрийн удирдлага дор төсвийн шууд захирагчийг харьяалах эрх бүхий төсвийн төвлөрүүлэн захирагчтай байж болно”, 15.4-д “Төсвийн төвлөрүүлэн захирагч нь түүнд харьяалагдах төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ”, 15.4.1-д “төсвийн ерөнхийлөн захирагчийн энэ хуулийн 14.2.2, 14.2.3, 14.2.5, 14.2.8–д заасан болон төсвийн шууд захирагчийн энэ хуулийн 16.5-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх” гэж заасан байна.

Төсвийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4-д заасны дагуу Алтанцөгц сумын Засаг дарга Алтанцөгц сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн үүргийг гүйцэтгэж байна. Алтанцөгц сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2017 оны орон нутгийн төсвөөс аймгийн төрийн сангаар дамжуулан Алтанцөгц сумын төрийн сангаас олгосон байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчтай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд байгууллагатай холбоотой Төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Алтанцөгц сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

Аудитын шалгуур үзүүлэлт, аудитынаргазүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорилболон нарийвчилсан горим, түүний үр дүн:

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Алтанцөгц сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд дүгнэлт өгөх үүднээс төсвийн захирагчийн удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан горим, сорил 29-г гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад боловсруулсан санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулан мөрдөж ажиллаагүй байна.

Алтанцөгц сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд “бага” буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

Алтанцөгц сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг Төрийн сангийн “Пластик” програмаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна.

Дотоод хяналт:

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм. Алтанцөгц сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн дотоод хяналт эрсдэлийг төлөвлөлтийн үед “бага” гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналт хэвийн байна.

Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:

2017 оны батлагдсан төсвийг сар, улирлын хуваарийн дагуу аймгийн Аймгийн Засаг даргын тамгын газрын Санхүү төрийн сангийн хэлтсээс орон нутгийн төсвөөс аймаг, сумын төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.

1.Төсвийн орлогын гүйцэтгэлийн талаар:

Аймгийн ИТХ-ын 2017 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн ээлжит хуралдааны 25 тоот тогтоолоор Алтанцөгц сумын 2017 оны Орон нутгийн төсвийн орлогын тодотгосон төлөвлөгөөг 15,7 сая төгрөгөөр буюу хэвээр баталжээ.

Орлогын бүтцийг авч үзвэл нийт орлогын 60,7 хувийг ХАОАТатвар, хөрөнгө борлуулсаны татвараас, 26,9 хувийг бусад татвараас, 12,4 хувийг өмчийн татвараас оруулахаар төлөвлөжээ.

Орон нутгийн төсвийн орлогын гүйцэтгэлийг хүснэгтээр харуулбал: /төгрөг/

Үзүүлэлт	төлөвлөгөө	гүйцэтгэл	зөрүү	хувь
Нийт орлогын дүн	15.744.2	18676.4	2932.2	118.6%
Татварын орлого	9550.0	11475.8	1832.1	120.2%
ХАОАТатвар	9550.0	11475.8	1925.8	120.2%
Өмчийн татвар	1950.0	1226.0	-724.0	62.8%
Бусад татвар	4244.2	4874.5	630.3	114.8%
Татварын бус орлого	0.0	1100.1	1100.1	
Б.ХӨРӨНГИЙН ОРЛОГО		0,00		

Гүйцэтгэлээр сумын орон нутгийн орлогод 18,7 сая төгрөгийн орлого оруулж төлөвлөгөөг 2,9 сая төгрөгөөр буюу 18,6 хувиар давуулан биелүүлжээ.

Нийт орлогын 61,4 хувийг ХАОАТатвар, хөрөнгө борлуулсаны татвараас, 26,1 хувийг бусад татвараас, 6,6 хувийг өмчийн татвараас, 5,9 хувийг татварын бус орлогоос оруулжээ. Татварын бус орлогын төлөвлөгөө өгөгдөөгүй ба хүү торгуулийн орлогоос 1,1 сая төгрөгийн орлого оруулсан ба энэ нь орлогын 5,9 хувийг эзэлж байна.

Гүйцэтгэлийг орлогын нэр төрлөөр авч үзэхэд ХАОАТатвар 2,0 сая төгрөгөөр буюу 20,0 хувиар, бусад татвар 0.6 сая төгрөгөөр буюу 14,9 хувиар давж, татварын бус орлогоос 1,1 сая төгрөг оруулж орон нутгийн орлогын төлөвлөгөө нийт дүнгээр давж биелэгдсэн байна.Өмчийн татварын орлого 0,7 сая төгрөгөөр буюу 37,1 хувиар тасарсан байна.

Сумын төрийн сан дахь орон нутгийн орлогын 995 тоот дансаар 18,7 сая төгрөгийн орлого оруулж, 15,7 сая төгрөгийг орон нутгийн төсвийн байгууллагуудын урсгал санхүүжилтэнд шилжүүлж, оны эцэст орон нутгийн төсвийн ерөнхий орлогын 910 тоот дансанд 3,6 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарчээ.

Сумын орон нутгийн татварын ерөнхий орлогын 910 тоот дансанд цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын татвараас 91,0 сая төгрөгийн орлого оруулж, аймгийн төсөвт бүрэн төвлөрүүлсэн байна.

2.Төсвийн зарлагын гүйцэтгэлийн талаар:

- Алтанцөгц сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн өөрийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой төсөвт байгууллагуудын хөтөлбөр, арга хэмжээнд зориулан тайлант онд урсгал зардалд нийтдээ 1748,0 сая төгрөгийн төсөв батлагдсан байна.

Санхүүжүүлэх эх үүсвэрийн хувьд 308,6 сая төгрөгийг санхүүгийн дэмжлэгээр, 15,7 сая төгрөгийг орон нутгийн орлогоос, 1322,4 сая төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээр, Орон нутгийг хөгжүүлэх сангаас 35,9 сая төгрөгийг, үндсэн үйл ажиллагааны орлогоос 65,4 сая төгрөг бүрдүүлэн 1748,0 сая төгрөг зарцуулахаар тусгагджээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэлийн талаарх мэдээллийг дор нэгтгэн харуулав.

/сая төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	Зөрүү
1	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	1748,1	1736,1	0,7%	12,0
1.1	Урсгал зардал	1682,6	1682,6	0,0%	00,0
1.2	Хөрөнгийн зардал	0	0	0.0%	0.0
2	Зардлыг сахүүжүүлэх эх үүсвэр	1682,6	1682,6	0,0%	0,0
2.1	Тусгай зориулалтын шилжүүлэгээс	1322,4	1322,4	0,0%	0.0
2.2	Орон нутгийн төсвөөс	324,3	324,3	0,0%	0,0
2.3	Орон нутгийн хөгжлийн сангаас	35,9	35,9	0,0%	0,0
2.4	Төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос	65,5	53,5	18,3%	12,0

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 308,6 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг, орон нутгийн орлогоос 15,7 сая төгрөгийн, тусгай зориулалтын шилжүүлгээр 1322,4 сая

Алтанцөгц сумын ТТЗ-ийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудит төгрөгийн санхүүжилт, Орон нутгийг хөгжүүлэх сангаас орлогын шилжүүлгээр 35,9 сая төгрөгийн санхүүжилт хүлээн авч, үндсэн үйл ажиллагааны орлогоос 53,5 сая төгрөгийн орлого бүрдүүлэн нийтдээ 1736,1 сая төгрөгийн зарлага санхүүжилтээр үйл ажиллагаа явуулж, батлагдсан төсвөөс 12,0 сая төгрөгөөр бага зарлага гаргажээ.

Энэ нь Сум хөгжүүлэх сангийн төлөвлөсөн орлого 11,9 сая төгрөгөөр дутуу биелэгдэж, төсөвт байгууллагуудын өөрийн орлого 0,1 сая төгрөг тасарсантай холбоотой. Тус сумын 2016 оны давсан хэсэг 0,7 сая төгрөгийг зарцуулаагүй байна.

Тайлант хугацаанд Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлд заасан нэмэлт төсвийн дансаар нийт 19,7 төгрөгийн санхүүжилт хүлээн авч зарцуулсны дотор урсгал зардалд 19,7 сая төгрөгийг зарцуулсан байна.

Үүнд:ЗДТГазар Статистикийн хэлтсээс мал тооллогын зардалд 0,6 сая төгрөгийн, ХХААГазраас бруцеллёзын зардалд 11,9 сая төгрөгийн бүгд 12,6 сая төгрөгийн, Бүрэн дунд сургууль Боловсрол, соёл, урлагийн газраас 7,1 сая төгрөгийн нэмэлт санхүүжилт авч зориулалтын дагуу зарцуулжээ.

Төсвийн гүйцэтгэлийг байгууллага бүрээр хүснэгтээр нэгтгэн харуулбал:

/мянган төгрөгөөр/						
№	Үзүүлэлт	Төлөвлөгөө /Сумын ИТХ- аас баталсан/	Аймгийн тодотгосон төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
	Мөнгөний эхний үлдэгдэл			18,258.1		
	Орон нутгийн төсвийн зарлагын дүн	1,748,073.2	1,748,073.2	1,736,984.9	11,088.3	99.4
1	Сумын ИТХурал	54,851.0	54,851.0	54,851.0	-	100.0
2	Сумын ЗДТГазар	301,719.0	301,719.0	301,719.0	-	100.0
3	Ахлах сургууль	790,768.3	790,768.3	790,768.3	-	100.0
5	ЭМТөв	275,446.9	275,446.9	275,446.9	-	100.0
6	Хүүхдийн цэцэрлэг	201,374.8	201,374.8	201,274.8	100.0	100.0
7	Соёлын төв	56,267.3	56,267.3	56,266.8	0.5	100.0
8	ОНХСан	17,794.1	17,794.1	23,066.3	- 5,272.2	
9	СХСан	49,851.8	49,851.8	33,591.8	16,260.0	
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр:	1,748,073.2	1,748,073.2	1,736,081.8	11,991.4	99.3
1	Улсын төсвийн тусгай шилжүүлэг	1,322,447.3	1,322,447.3	1,322,447.3	-	100.0
2	Улсын төсвийн санхүүгийн дэмжлэг	324,270.0	324,270.0	324,270.0	-	100.0
3	ОНХСан, СХСан, ЭЭСан	35,894.1	35,894.1	35,894.1	-	100.0
4	Үндсэн үйл ажиллагааны орлого	42,210.0	42,210.0	39,270.4	2,939.6	93.0
5	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	23,251.8	23,251.8	14,200.0	9,051.8	61.1
	ОНОрлогын давсан хэсгээс санхүүжүүлсэн				-	
	Мөнгөний эцсийн үлдэгдэл			17,355.0		

Төсөвт байгууллагууд батлагдсан төсөвтөө багтаан үйл ажиллагаа явуулж, ОНХСангийн төсөв оны эхний мөнгөний үлдэгдлийн зарцуулалтаар гүйцэтгэл нь хэтрэлттэй харагдаж, СХСангийн орлого тасарсанаас хэмнэлттэй байна.

Алтанцөгц сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа төсөвт байгууллагуудын 2017 оны орон тоог удирдах ажилтан 12, гүйцэтгэх ажилтан 80, үйлчилэх ажилтан 38, гэрээт 22 бүгд 152 орон тоо батлагдсанаас гүйцэтгэлээр 156 орон тоо ажиллуулж, орон тоо нийт дүнгээр 4-ээр хэтэрсэн байна.

Үүнд: Бүрэн дунд сургууль 1 жижүүр, Эрүүл мэндийн төв 1 үйлчлэгч, Хүүхдийн цэцэрлэг 1, Соёлын төв 1 бүгд 4 орон тоог илүү ажиллуулсан байна.

Төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн талаар:

Алтанцөгц сумын ИТХурал, Соёлын төвийн 2017 оны санхүүгийн тайланд итгэл үзүүлж, ЗДТГазар, ОНХСан, СХСан, ЭЭСанг түүвэрт хамруулж, Бүрэн дунд сургууль, хүүхдийн цэцэрлэг, Эрүүл мэндийн төвийн санхүүгийн тайланд бие даасан дүгнэлт гаргалаа.

ТТЗ-ийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдэж ирсэн байгууллагуудыг дүгнэлт, алдаа зөрчлийг хүснэгтээр харуулбал:

Төсвийн шууд захирагчийн нэр	Алдаа, зөрчлийн дүн /мян. төг/	Аудиторын санал дүгнэлт бүгд	Үүнээс			
			Зөрчилгүй санал дүгнэлт	Хязгаарлалттай санал дүгнэлт	Сөрөг санал дүгнэлт	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
Сумын ИТХурал	-	-	-			
Сумын ЗДТГазар	972,0-	-	-			
Бүрэн дунд сургууль	-	1	1			
Эрүүл мэндийн төв	-	1	1			
Хүүхдийн цэцэрлэг	-	1	1			
Соёлын төв	-	-	-			
ТТЗ-ийн СНТайлан	-	1	1			
Дүн	972,0	4	4			

Алтанцөгц сумын төсөвт байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийтдээ 0,9 сая төгрөгийн алдаа зөрчил илэрч, акт ттогтоосон байна.

Шилэн дансны мэдээлэл

Алтанцөгц сумын Засаг даргын Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй. Шилэн дансны тухай хуулинд заасны дагуу shilendans.gov.mn вэб сайтанд байгууллагын 2017 оны батлагдсан төсвийн мэдээллийг оруулсан байна.

ҮАГ-ын аудитын нэгдсэн төлөвлөгөөний дагуу 2017 оны 1-9 дүгээр сарын Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн нийцлийн аудитаар хуулийн 4-р зүйлийн 4.1.3, 6-р зүйлийн 6.1.1, 6.1.3, 6.1.4, 6.1.5, 6.1.6, 6.4.5, 6.3.8, 6.3.9 дэх заалтуудыг зөрчсөн 5,0 сая төгрөгийн зөрчил илэрч албан шаардлага өгөгдөж, биелэлтийг 2017.12.22-ны өдрийн №1/206 тоотоор ирүүлсэн байна.

Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 10 эрсдлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 29 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Үр дагаварыг тодорхойлж чадвал: Санхүүгийн тайлангийн аудитаар алдаа зөрчил илрээгүй.

Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар:

Алтанцөгц сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний санхүүжилт, орон нутгийн орлогуудыг төрийн сангийн хуулга, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан горим, сорилын аргаар шалгалаа.

Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:

Аудитаар санхүүгийн тайланд нөлөөлөх материаллаг алдаа зөрчил гараагүй. Санхүүгийн тайлангийн аудитаар дараахь алдаа зөрчил илэрлээ. Үүнд:

1. Сум хөгжүүлэх сан нь жилийн эцсийн байдлаар 191,6 сая төгрөгийн зээлийн авлагатай бөгөөд авлагын үлдэгдэлд тайлант хугацааны хүүг тооцож, орлогоор бүртгэж аваагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Асуудлын бүртгэлд тэмдэглэж цаашид анхаарч ажиллахыг зөвлөв.

2. Шүүхийн шийдвэрээр сумын ИТХ, ЗДТГ-ын 2 ажилтан ажилгүй байсан хугацааны цалинд 14,2 сая төгрөгийг аймгийн төсвийн урьд оны үлдэгдлээс санхүүжүүлж олгосон байна.

Шийдвэрлэсэн нь: Асуудлын бүртгэлд тэмдэглэв.

Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1, 103.2-т зааснаар ямар нэг арга хэмжээ авагдаагүй байна.

3. Засаг даргын тамгын газрын даргын тушаалаар сахилгын шийтгэл ногдуулсан, сахилгын шийтгэлгүйд тооцох хугацаа нь дуусаагүй байсан хавсралтанд заасан нэр бүхий ажилчдад Засгийн газраас олгосон 300000 төгрөгийн нэг удаагийн мөнгөн урамшуулалыг олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 41 дүгээр зүйлийн 41.2.3 “төсвийн гүйцэтгэлийн хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж тайлагнах”, Хөдөлмөрийн тухай хуулийн 131 дүгээр зүйлийн 131.4-т “Сахилгын шийтгэл ногдуулснаас хойш нэг жил өнгөрвөл сахилгын шийтгэлгүйд тооцно”, Засгийн газрын 2017 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн хуралдааны 52 дугаар “Урамшуулал олгох тухай” тэмдэглэлд “УИХ-ын 2017 оны 67 дугаар тогтоолын дагуу төрийн албан хаагчид 300000 төгрөгийн урамшуулал олгох тухай асуудлыг хэлэлцээд сахилгын шийтгэл хүлээсэн бөгөөд сахилгын шийтгэлгүйд тооцох хугацаа нь дуусаагүй байгаа албан хаагчаас бусад төрийн албан хаагчдад мөнгөн урамшуулал олгох арга хэмжээ авахыг төсвийн шууд захирагч нарт даалгав” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зориулалт бус олгосон урамшуулал 1,0 са ятөгрөгийг нөхөн төлүүлэхээр акт тогтоов.

Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:

Алтанцөгц сумын ТТЗ-ийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудит Санхүүгийн тайлангийн аудитаар залруулагдаагүй алдаа байхгүй болно.

Анхаарал татахуйц бусад чухал асуудал:

Анхаарал татахуйц асуудал байхгүй.

Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:

Алтанцөгц сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн орон нутгийн орлогыг түүврийн аргаар түүвэрлэн үзсэн болно.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Алтацөгц сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангаар илэрсэн асуудлыг алдаа зөрчлийн нэгтгэл маягтаар нэгтгэж харуулав.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:

Алтанцөгц сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2016 оны нэгтгэсэн санхүүгийн тайлангаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

Зөрчилгүй санал дүгнэлт

Алтанцөгц сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Аудитлагдсан санхүүгийн тайлан 9 хуудас, хавсралтууд хуудсыг тус тус хавсаргав.

АУДИТЫН ТАЙЛАНГ:

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

М.ХУАНГАН

Огноо:

АУДИТЫН МЕНЕЖЕР

Х.ЖЕНИСБЕК

Огноо: 2018.03.20

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР

Б.ҮҮРИЙНТУЯА

Огноо: 2018.03.19

